



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 15/03

Пионер толгой

Уул уурхайн талаар авах арга
хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1.5, 1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 15 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Тус сумын Буга 3 дугаар багийн нутаг “Тээлийн Хүрэн-Ганга” гэх газарт ашигт малтмал олборлох МУ-12500 тоот тусгай зөвшөөрөлтэй “МБГЦ ХХК” компани талбай нь “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтад заасны дагуу усны эх бүрэлдэх усан сан бүхий газар нутагт хамаарах бөгөөд дээрх тусгай зөвшөөрөл нь бүхлээрээ хамрагдаж байгаа тул ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг холбогдох дээд байгууллагуудад уламжилсугай.

2. Тогтоолыг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэн ажиллахыг Сумын Засаг дарга (Б.Гантулга), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Ш.Нархүү) нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга С.Алтанцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ЭРДЭНЭ-ОЧИР



642301005